



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.01 № 1365
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН Н.ЭНХТУЯА
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн Нацагдоржийн Энхтуяагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Нацагдоржийн Энхтуяагийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн


Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Нацагдоржийн Энхтуяагийн мөрийн хөтөлбөр / ? хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: ? хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ **Б.НОМИНБААТАР**



**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2020 ОНЫ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Н.ЭНХТУЯАГИЙН
“УХААЛАГ УЛААНБААТАР” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

НЭГ. УХААЛАГ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

1. Нийслэлийн төрийн үйлчилгээг цахимжуулж, хялбар, уян хатан болгоно.
2. Иргэдийн санал гомдол, санал санаачилгыг хүлээн авах системийг боловсронгуй болгож, хялбаршуулна.
3. Иргэд нийслэлийн ИТХ-ын болон Засаг даргын шийдвэртэй холбоотойгоор төрийн шийдвэрт оролцох оролцоог хялбаршуулж, төрийн шийдвэрт санал өгөх боломжийг бүрдүүлнэ.
4. Нийслэлээс хийж хэрэгжүүлж буй ажлуудыг иргэдэд хүргэх, мэдээлэх тогтолцоог илүү хялбар болгоно.

ХОЁР. УХААЛАГ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

1. Нийтийн тээврийг ухаалаг болгох тогтолцоонд ахиц гаргаж, тээврийн хэрэгсэл, зам, буудал, зорчигч хоорондын харилцан уялдааг бий болгоно.
2. Нийтийн тээврээр зорчих төлбөрийн тогтолцоог илүү уян хатан болгохын тулд гар утасны аппликешнд суурилсан төлбөрийн тогтолцоог нэвтрүүлнэ.
3. Халуун хүйтэн усны тоолуурыг ухаалаг болгох ажилд ахиц гаргаж, нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлнэ.
4. Нийтийн үйлчилгээний салбарт дата, удирдлага, хяналтын тогтолцоонд олон улсын дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.
5. Хог хаягдлын менежментийг илүү ухаалаг болгож, хаягдлыг хянах, зөөвөрлөх, зайлуулах менежментэд ахиц гаргана.
6. Замын хөдөлгөөний хяналтын датаг ашиглаж иргэд зорчих замаа сонгодог, урьдчилж төлөвлөдөг боломжийг олгох ажлыг хэрэгжүүлнэ.

ГУРАВ. УХААЛАГ БИЗНЕСИЙН ОРЧИН

1. Нийслэлийн статистик мэдээллийг илүү бодитой болгох боломжийг бизнесийн байгууллагуудын оролцоотой хэрэгжүүлнэ.
2. Нийслэлд бизнес эрхлэх тусгай зөвшөөрлийг цахимжуулж, төрийн хүнд суртал, авилгаас ангид байлгах ажлыг эхлүүлнэ.
3. Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан нийслэлийн эдийн засаг, бизнесийн орчны мэдээллийг голлох орнуудын хэл дээр авах хялбар тогтолцоог бий болгоно.
4. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд нийслэлийн хүний нөөц, хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн санг бий болгох ажлыг хэрэгжүүлнэ.

